

ХУВИЙН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөл (цаашид “Хуулийн төсөл” гэх)-ийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад чиглэсэн Зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 21.1-д заасан анхдагч хуулийн төсөл² хэлбэрээр боловсруулагдсан байна.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”³-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараахь үе шатаар хийж гүйцэтгэлээ:

- 1) Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 2) Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- 3) Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 4) Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Үнэлгээний үр дүнд үндэслэн Дүгнэлт болон Зөвлөмжийг тусгайлан боловсруулсан болно.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д⁴ заасны дагуу 6 шалгуур үзүүлэлтээс дараахь 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

¹ Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он.

² “Нийгмийн харилцааны тулгамдсан асуудлыг харгалзан тухайн хуульд нэмэлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, эсхүл тодорхой зүйл заалтыг хүчингүй болсонд тооцох асуудлаар хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.” Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг.

³“Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт.

⁴ Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 “... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно”.

Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Харилцан уялдаа;

I. Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

➤ **Зорилгод хүрэх байдал:**

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго бол тухайн хуулийн төслийн зохицуулалт нь анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох юм.

Иймд хуулийн төслийн зохицуулалт болон хуулийн төслөөр тодорхойлогдсон зорилт, мөн тус хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлага, зохицуулалтын хүрээнд нийцсэн эсэх, төсөлд тусгасан зохицуулалтын хувилбар нь дээрх шаардлагыг хангаж чадахуйц, түүнийг тодорхой илэрхийлж чадсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ **Ойлгомжтой байдал:**

Хууль нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар аливаа хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Иймд тус хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 30, 31, 32 дугаар зүйлд заасан нийтлэг шаардлага болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын⁵ Хоёрдугаар бүлгийн бүлгийн Гурав⁶, Дөрөв⁷, Тавдугаарт⁸ заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ **Харилцан уялдаа:**

Хуулийн төслийн эх бичвэр нь Монгол Улсын Үндсэн хууль, хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомж болон хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээлгэж байгаа субьектүүдийн чиг үүрэг нь давхардал, хийдэл, зөрчилгүй, хэрэгжих боломжтой байх шаардлагатай.

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

⁶ Гурав.Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах шаардлага.

⁷ Дөрөв. Хуулийн төслийн эх бичвэрт хэрэглэх арга ажиллагаа.

⁸ Тав.Хуулийн төсөлд хэрэглэх онцлог бичвэр.

Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд⁹ заасан нийтлэг шаардлага болон Монгол Улсын Засгийн газраас баталсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын Хоёрдугаар бүлгийн Хоёрдугаарт¹⁰ заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

➤ **Хүлээн зөвшөөрөгдөх байдал:**

Тус шалгуур үзүүлэлтээр боловсруулсан хуулийн төсөлд төрийн байгууллагад шинээр олгохоор заасан эрх хэмжээ болон бусад этгээдэд хүлээлгэсэн үүрэг нь бодит байдалд хэрэгжих боломжтой эсэхийг судлан тогтооно.

Энэхүү шалгуур үзүүлэлтээр төрийн байгууллага болон бусад этгээдэд шинээр олгосон эрх хэмжээ бүхий зохицуулалтыг хамруулан шалгаж, энэхүү чиг үүрэг нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, хүний эрхийн суурь зарчимд нийцсэн эсэх, хууль хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд нийцэж байгаа эсэхийг тогтооно.

Мөн энэхүү чиг үүргийг хуулийн үйлчлэлд хамаарах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Иймд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг хуулийн төслийн бүтцийн дагуу дараахь байдлаар тогтоосон болно.

Хүснэгт 1.

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн 2 үндсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх. Хуулийн төслийг бүхэлд нь судалж, эдгээр 2 зорилтыг хангах хэмжээнд хуулийн төслийг боловсруулсан эсэхийг шалгах.
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.

⁹ 29 дүгээр зүйл. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага.

¹⁰ Хоёр.Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих шаардлага.

3	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах.
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн 21, 22 дугаар зүйл, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг хамруулна.	Хууль хэрэгжүүлэгч байгууллага болон хуулийн үйлчлэлд хамаарах иргэн, хуулийн этгээдийн төлөөлөлтэй ярилцлага хийх

1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан үндэслэл, хэрэгцээ шаардлагад болон хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д заасан Хуулийн зорилгод энэхүү хуулийн төслийн зохицуулалт нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Үүний дагуу хуулийн төслийн үзэл баримтлал нь тандан судалгааны дүнд гарсан Зөвлөмжтэй хэрхэн нийцэж байгаад болон Үзэл баримтлалд тусгагдсан зорилтууд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтуудтай хэрхэн нийцэж байгаад дүн шинжилгээ хийнэ.

Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд:

1. Монгол Улсад тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор төрийн бус өмчид тулгуурлан албан журмын болон сайн дурын тэтгэврийн нэмэлт даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, хувийн тэтгэврийн санг бий болгох, зарцуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах;

2. Хувийн тэтгэврийн хөтөлбөрт оролцогчийн эрх ашгийг хамгаалах, хувийн тэтгэврийн сан болон төрийн захиргааны байгууллагын эрх, үүргийг тодорхойлох, тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын удирдлагыг тогтоох, тэтгэвэр олгох харилцааг зохицуулна.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

Зорилт-1. Монгол Улсад тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор төрийн бус өмчид тулгуурлан албан журмын болон сайн дурын тэтгэврийн нэмэлт даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, хувийн тэтгэврийн санг бий болгох, зарцуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах талаар:

Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хувийн тэтгэврийн санд шимтгэл төлөх, хувийн тэтгэврийн гэрээ байгуулж данс нээх, тэтгэврийн хуримтлал үүсгэх, хуримтлалаас хөрөнгө оруулалт хийх, тэтгэвэр олгох болон хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, холбогдон үүсэх харилцааг зохицуулах, шимтгэл төлөгч, эрх залгамжлагч, өвлөгчийн эрх ашгийг хамгаалахад оршино.

Хууль санаачлагч хувийн тэтгэврийн хуримтлал бүрдүүлэх, тэтгэвэр авах, хувийн тэтгэврийн сангийн шаардлага, эрх зүйн үндсийг тогтоохыг зорьсон байна:

- Хувийн тэтгэврийн хуримтлал бүрдүүлэх, тэтгэвэр авах харицлааг 4, 6, 7, 10, 23, 24 дүгээр зүйл тусгажээ.

Хуулийн төслөөр улсын тэтгэврийн тогтолцооноос гадна хувийн тэтгэвэр авах бололцоог бүрдүүлсэн байна. Түүнчлэн Хувийн тэтгэврийн хуулийн төслийг дагалдан гарах холбогдох хуулийн төслүүдийг боловсруулсан байгаа нь хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үзэл баримтлалд дурдагдсан зорилгод хүрэхээр байна гэж дүгнэж байна.

Зорилт-2. *Хувийн тэтгэврийн хөтөлбөрт оролцогчийн эрх ашгийг хамгаалах, хувийн тэтгэврийн сан болон төрийн захиргааны байгууллагын эрх, үүргийг тодорхойлох, тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын удирдлагыг тогтоох, тэтгэвэр олгох харилцааг зохицуулах талаар:*

- Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, батлан мөрдүүлэх дүрэм, журмуудыг 32, 33 дугаар зүйлд,
- Тэтгэврийн хөрөнгийн аюулгүй байдал, баталгаа болон түүний менежмент, хөрөнгө оруулалтын талаар 17-20 дугаар зүйлд,
- Хувийн тэтгэврийн сангийн талаар хуулийн төслийн 11-16 дугаар зүйлд тус тус заасан байна.

Хувийн тэтгэврийн хуримтлал бүрдүүлэгч, шимтгэл төлөгчийн эрх ашгийн өмнөөс төрийн хяналт шалгалт, холбогдох дүрэм журмыг батлан мөрдүүлэхээр Санхүүгийн зохицуулах хороонд эрх, үүргүүдийг тодорхойлсон байна. Мөн хувийн тэтгэврийн сангийн тогтвортой байдал, тэтгэврийн хөрөнгийн аюулгүй байдал, өгөөжийн нэмэгдүүлэх үүрэг бүхий холбогдох байгууллагуудын шаардлага, үүрэг оролцоог тусгаж өгсөн байна.

2. Ойлгомжтой эсэх:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Мөн хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан, анализ хийсэн болно.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасан анхдагч хуулийн төсөл хэлбэрээр бичигдсэн 10 бүлэг, 39 зүйлтэй, хуульд заасан шаардлагыг хангасан хуулийн төслийн бүтцийн дугаарлалттай байна.

Мөн хуулийн төсөл нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын¹¹ Гуравдугаар бүлэгт заасан Анхдагч хуулийн төсөл боловсруулах бүтцийн болон хэлбэрийн шаардлагыг хангасан байна. Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэгт заасанд нийцсэн байна.

Мөн хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх, тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх зэрэг шаардлагад болон мөн хуулийн 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын нийтлэг шаардлагад нийцсэн байна.

Гэхдээ цаашид хуулийн төслийн ач холбогдолыг ойлгуулах, танилцуулах чиглэлээр нэмэлт мэдээлэл түгээх, хэлэлцүүлгийг өргөн хүрээнд зохион байгуулах зэрэгт анхаарах нь зүйтэй байна.

3.Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцсон.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 –т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд аливаа байдлаар зөрчилдөөгүй байна.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зарчмын томоохон зөрчил байхгүй байна.

¹¹ Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт.

3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Энэхүү хуулийн төсөлд шаардлагатай хуулиудаас эшлэл хэрэглэсэн байна.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх	Тус хуулийн төслийг дагаж нэмэлт оруулах 1, өөрчлөлт оруулах 3 хуулийн төслийг тус тус боловсруулсан байна.

○ Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилт болон хуулийн зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслөөр тодорхойлсон нэр томъёо энэ шаардлагыг хангасан.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал дүн шинжилгээний хүрээнд илрээгүй болно.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.

	хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх		
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зарчмын зөрчилтэй зохицуулалт илрээгүй болно.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	-	Зарим үүргийг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлдэг өмнө тогтсон практикийг өөрчлөөгүй болно.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Татварын хуулиас бусад хуульд татвар, хураамж тогтоогоогүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх		Хуулийн төсөлд хамааралгүй тул тусгайлсан зохицуулалт тусгагдаагүй.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий		Хуулийн төсөлд тусгайлсан зохицуулалт тусгагдаагүй.

	болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх		
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм	Тухайн хуулийг зөрчсөн аж ахуйн нэгжийг Зөрчлийн хуульд заасан хариуцлага, төрийн албан тушаалтанд Төрийн албаны хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр тусгасан байна.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл, заалт зарчмын хувьд өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нөлөө тооцох үнэлгээг УИХ-ын гишүүн Н.Учралын санаачлан боловсруулсан Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөл, тус хуулийн төслийн Үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

Үнэлгээнд хуулийн төсөл, үзэл баримтлалаас гадна эрх бүхий байгууллагуудаас энэхүү хуулийн төслөөр зохицуулах харилцаатай холбогдуулан батлан гаргасан журам, стандарт, статистик тоон үзүүлэлтүүд, судалгаа, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд зэрэг олон нэмэлт материалыг ашигласан болно.

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараахь **Дүгнэлтийг** хийж, **Зөвлөмж** боловсрууллаа:

Дүгнэлт:

- **Зорилгод хүрэх байдал:** Хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг бүрэн тусгасан байна.
- **Ойлгомжтой байдал:** Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээ боловсруулагдсан ойлгомжтой байна.

- Харилцан уялдааг хангасан байдал: Хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

Зөвлөмж

Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөл нь хувийн тэтгэврийн хуримтлал бүрдүүлэх, түүнийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Хуулийн төслийг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд үзэл баримтлал болон хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байна.

---oOo---